

# ХасБанкинд зориулсан синдикат зээл

Улс: Монгол

Төслийн дугаар: 43542

Үйл ажиллагааны салбар: Банкуудад зээл олгох

Улсын/хувийн: Хувийн

Байгаль орчны ангилал: FI

Захирлуудын зөвлөлийн  
хурлын тов: 2012 оны 5 дугаар сарын 29

Статус: Эцсийн хяналтанд тэнцсэн, Захирлуудын  
зөвлөлийн шийдвэр хүлээгдэж байгаа

Төслийн товч танилцуулга  
нийтлэгдсэн он сар өдөр: 2012 оны 4 дүгээр сарын 27

## Төслийн танилцуулга

Бичил, жижиг, дунд бизнест олгох урт хугацааны зээлийн эх үүсвэрээр хангах зорилгоор ЕСБХБ-наас Монгол Улсын ХасБанкинд 30 сая хүртэлх ам. долларын А/В ангиллын зээл олгох судалгаа шинжилгээг хийж байна. Зээлийн А хэсгийг ЕСБХБ өөрөө гаргах бөгөөд санхүүжилтийн хэмжээ 10 сая ам. доллар хүртэл хэмжээтэй байна. Мөн 5 сая ам. долларыг Тайваны TaiwanICDF сангаас санхүүжүүлэхээр яригдаж байна. Харин үлдсэн 15 сая ам. долларыг санхүүгийн байгууллагуудын синдикат санхүүжилтээр шийдэх талаар бүхий л арга хэмжээг авна. Монгол Улсын эдийн засаг, аж ахуйн салбар эрчимтэй өсч өргөжиж байгаатай холбоотойгоор дунд, урт хугацааны санхүүжилтийн нэмэлт эх үүсвэрүүд шаардлагатай болж байгаа бөгөөд үүнийг энэхүү зээлээр хангах зорилт тавьж байна.

## Шилжилтийн нөлөөлөл

Монгол Улсын бичил, жижиг, дунд бизнесүүд дунд, урт хугацааны санхүүжилт авах боломж хязгаарлагдмал хэвээр байгаа энэ үед төслийн хүрээнд урт хугацааны санхүүжилт олгогдох болно. Арилжааны зээлдүүлэгчид энэхүү синдикатад оролцсоноор санхүүжилт хийх өөр арга зам байдгийг Монголын санхүүгийн бусад байгууллагуудад харуулах болно. Мөн түүнчлэн төсөл хэрэгжсэнээр ХасБанкны гадаад валютын зээлийн журмын цочролын шинжилгээ, эдгээр зээлтэй холбоотой эрсдэлийг олж тогтоох үйл ажиллагааг боловсронгуй болгож, банкны үйл ажиллагаа явуулах дээд түвшний стандартыг Монголын бусад банкуудад харуулах болно.

## Харилцагч

ХасБанк нь Монгол Улсын дөрөв дэхь том банк бөгөөд улсын хэмжээнд тархсан 92 салбар нэгжээр дамжуулан бичил санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг. Сүүлийн жилүүдэд тус банк нь бичил санхүүгийн салбарт хуримтлуулсан туршлагаа ашиглаж, ЖДБ-ийн салбарт үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд анхаарсан нь Монгол Улсын эдийн засгийн хөгжилтэй шууд холбоотой юм.

## **ЕСБХБ-наас олгох санхүүжилт**

10 сая ам. доллар хүртэл.

## **Төслийн өртөг**

30 сая ам. доллар хүртэл.

## **Байгаль орчны нөлөөлөл**

FI ангилалд багтаж байгаа. ХасБанк нь ЕСБХБ-наас авсан зээлийн өрийн үлдэгдэлтэй бөгөөд Байгаль орчны бодлого, Байгаль орчин, нийгмийн журмыг боловсруулж гаргасан нь PR 2 ба 9-ийн шаардлагыг хангаж байна.

## **Техник хамтын ажиллагаа**

ХасБанкин дээр одоогоор техник хамтын ажиллагааны төсөл хэрэгжиж байгаа бөгөөд уг төсөл ЖДБ, компанийн харилцагчдад үзүүлэх бүтээгдэхүүн үйлчилгээгээ өргөжүүлэх тус банкны төлөвлөгөөг дэмжих зорилготой юм. Санхүүжилтийг Солонгосын Засгийн газраас гаргасан.

Өмнө нь тус банкны бичил, жижиг, дунд бизнесийн зээлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор 2008-2010 онуудад техникийн хамтын ажиллагаа хэрэгжүүлсэн. Санхүүжилтийг ЕСБХБ-ны Эрт шилжилтийн улсын сан, Хувь нийлүүлэгчдийн тусгай сангаас гаргасан.

Энэ төслийн хүрээнд техник хамтын ажиллагаа нэмж хэрэгжихгүй болно.

## **Компанийн харилцах хаяг**

ХасБанкны Төв албаны байр, Улаанбаатар-14200, Шуудангийн салбар 20А,  
шуудангийн хайрцаг -721, МОНГОЛ УЛС

Цахим хаяг: [info@xacbank.mn](mailto:info@xacbank.mn)

Цахим хуудас: [www.xacbank.mn](http://www.xacbank.mn)

Утас: +976 11 318185

Факс: +976 11 328701

## **Бизнесийн боломжууд**

Бизнесийн боломж, худалдан авалтын талаар харилцагч компанитай холбоо барина уу.

## **Ерөнхий мэдээлэл авах**

ЕСБХБ-ны төслийн худалдан авалттай холбоогүй мэдээлэл авах:

Утас: +44 20 7338 7168; Факс: +44 20 7338 7380

Цахим шуудан: [projectenquiries@ebrd.com](mailto:projectenquiries@ebrd.com)

## Олон нийтэд мэдээлэл хүргэх бодлого

ЕСБХБ-ны стратеги, бодлого, үйл ажиллагааны талаар илүү сайн мэдээлэл, ойлголт өгөх үүднээс мэдээ мэдээллийг хэрхэн хүргэх, оролцогч талуудтай хэрхэн зөвлөлдөх асуудлыг Олон нийтэд мэдээлэл хүргэх бодлогод тодорхой заасан байдаг.

Олон нийтэд мэдээлэл хүргэх бодлоготой танилцах: [Text of the PIP](#)

## Төсөлтэй холбоотой санал гомдол хүлээж авах механизм

ЕСБХБ-наас төсөлтэй холбоотой санал гомдол хүлээж авах механизмыг бий болгож, тус банкнаас санхүүжүүлж байгаа төсөл, түүнтэй холбоотойгоор учирсан гэх эсвэл учирч болзошгүй хор хохиролтой холбоотой иргэд, байгууллагаас ирсэн санал гомдлыг хүлээн авч, хараат бус бие даасан үнэлэлт дүгнэлт хийх боломжийг бүрдүүлсэн. Төсөлтэй холбоотой санал гомдол хүлээж авах механизмтай холбоотой журамтай [www.ebrd.com/downloads/integrity/pcmrules.pdf](http://www.ebrd.com/downloads/integrity/pcmrules.pdf) хаягаар танилцана уу. Орос хэл дээрх хувилбар: <http://www.ebrd.com/downloads/integrity/pcmrulesr.pdf>.

Төсөлтэй холбоотой санал гомдол хүлээж авах механизмын хүрээнд санал гомдлыг ЕСБХБ-наас хамгийн сүүлд хийгдсэн санхүүжилтээс хойш 12 сарын дотор гаргана. Санал гомдол гаргах хугацааны талаар тодруулах шаардлагатай бол төсөлтэй холбоотой санал гомдол хүлээж авах механизм хариуцсан ажилтантай ([pcm@ebrd.com](mailto:pcm@ebrd.com) цахим хаягаар), эсвэл ЕСБХБ-ны Суурин төлөөлөгчийн газартай холбогдож, туслалцлаа авна уу.

---

Төслийн товч танилцуулгыг төслийн материал ЕСБХБ-ны Захирлуудын зөвлөлийн хурлаар хэлэлцэхээс өмнө боловсруулсан байна. Төслийн товч танилцуулга гарснаас хойш төслийн дэлгэрэнгүй мэдээлэлд өөрчлөлт орж болно. Төслийн товч танилцуулга нь ЕСБХБ-ны албан ёсны бодлогыг илэрхийлэхгүй болно.

Хамгийн сүүлд өөрчлөлт оруулсан 2012 оны 4 дүгээр сарын 27